



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ 2016-2019



Улаанбаатар хот 2020 он

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 2016-2019 оны гэмт хэргийн гаралтын байдлыг харьцуулан харвал: 2016 онд нийт 2811 гэмт хэрэг гарч байсан бол 2019 онд 3470 гэмт хэрэг гарч 2016 оноос 659 (23.4%) -өөр өссөн бол 2018 оноос 222 (6.0%)-оор буурсан байна. 2019 онд нийт гарсан хэргийн 260(7.5%) нь согтуугаар үйлдэгдсэн бол 2016 онд гарсан нийт хэргийн 472 (16.8%) нь согтуугаар үйлдсэн байна. Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2016 онд 77 гарсан бол 2019 онд 140 болж 63(81.8%)аар нэмэгджээ. Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2016 онд 77 гарсан бол 2019 онд 140 болж 63(81.8%)аар нэмэгджээ. Харин эмэгтэйчүүд оролцсон хэрэг 2019 онд 2016 оноос 72 (20.0%)-оор, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 2019 онд 2016 оноос 33(21.4%)-аар тус тус буурсан байна.

#### Хүснэгт 1. Гэмт хэргийн тоо, бүгд

| Он                    | Бүх хэрэг | Гэмт хэргийн ангилал |       | Согтуугаар үйлдэгдсэн | Хүүхэд оролцсон | Эмэгтэйчүүд оролцсон | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас |
|-----------------------|-----------|----------------------|-------|-----------------------|-----------------|----------------------|---------------------------------|
|                       |           | хөнгөн               | хүнд  |                       |                 |                      |                                 |
| 2016                  | 2811      | 1373                 | 144   | 472                   | 77              | 360                  | 154                             |
| 2017                  | 3691      | 2021                 | 1121  | 268                   | 104             | 238                  | 136                             |
| 2018                  | 3692      | 2429                 | 1263  | 214                   | 94              | 304                  | 118                             |
| 2019                  | 3470      | 2546                 | 924   | 260                   | 140             | 288                  | 121                             |
| $\frac{2019}{2016}\%$ | 123.4     | 185.4                | 641.7 | 55.1                  | 181.8           | 80.0                 | 78.6                            |
| $\frac{2019}{2018}\%$ | 94.0      | 104.8                | 73.2  | 121.5                 | 148.9           | 94.7                 | 102.5                           |

Сонгинохайрхан дүүрэгт 2019 онд гарсан нийт хэргийн 1611(46.4%) нь нэгдүгээр хэлтэст, 831(23.9%) нь хоёрдугаар хэлтэст, 1028(29.6%) нь гуравдугаар хэлтэст тус тус ногдож байна. 2016 оны байдлаар нийт гарсан хэргийн 1398(49.7%)нь нэгдүгээр хэлтэст, 739 (26.3%) нь хоёрдугаар хэлтэст, 674(24.0%) нь гуравдугаар хэлтэст тус тус ногдож байсан байна.

#### Хүснэгт 2. Гэмт хэргийн тоо, цагдаагийн хэлтсээр

| Цагдаагийн хэлтэс | Бүх хэрэг |      |      |      | $\frac{2019}{2016}\%$ | Гэмт хэргийн ангилал |      |      |      |      |      |      |      |
|-------------------|-----------|------|------|------|-----------------------|----------------------|------|------|------|------|------|------|------|
|                   |           |      |      |      |                       | хөнгөн               |      |      |      | хүнд |      |      |      |
|                   | 2016      | 2017 | 2018 | 2019 |                       | 2016                 | 2017 | 2018 | 2019 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
| I хэлтэс          | 1398      | 1711 | 1723 | 1611 | 115.2                 | 694                  | 935  | 1013 | 1159 | 66   | 497  | 710  | 452  |
| II хэлтэс         | 739       | 908  | 946  | 831  | 112.4                 | 337                  | 423  | 629  | 541  | 34   | 339  | 317  | 290  |
| III хэлтэс        | 674       | 1072 | 1023 | 1028 | 152.5                 | 342                  | 683  | 787  | 846  | 44   | 285  | 236  | 182  |

#### Хүснэгт 3. Гэмт хэргийн тоо, хэрэг үйлдэгдсэн байдлаар

| Цагдаагийн хэлтэс | Согтуугаар үйлдэгдсэн |      |      |      | Хүүхэд оролцсон |      |      |      | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас |      |      |      |
|-------------------|-----------------------|------|------|------|-----------------|------|------|------|---------------------------------|------|------|------|
|                   | 2016                  | 2017 | 2018 | 2019 | 2016            | 2017 | 2018 | 2019 | 2016                            | 2017 | 2018 | 2019 |
| I хэлтэс          | 153                   | 268  | 63   | 74   | 40              | 52   | 94   | 55   | 76                              | 62   | 47   | 41   |
| II хэлтэс         | 191                   | 82   | 108  | 82   | 14              | 23   | 39   | 46   | 46                              | 56   | 38   | 25   |
| III хэлтэс        | 128                   | 102  | 43   | 104  | 23              | 29   | 35   | 39   | 32                              | 18   | 33   | 55   |

2016 онд гарсан хэргийн 20(0.7%) нь хүнийг алах гэмт хэрэг байсан бол 2019 онд энэ нь 17(0.5%) болж буурсан байна. 2016 онд хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг хэрэг 212 (7.5%) гарсан бол 2019 онд 145(4.2%) гарсан байна. 2016 онд цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хэрэг гараагүй бол 2019 онд 1 гарсан байна. 2016 онд хүчингийн хэрэг 33(1.2%) гарсан бол 2019 онд 58(1.2%) болж 25 (75.7%)-аар нэмэгдсэн байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах хэрэг 2016 онд 8 (0.8%) гарсан бол 2019 онд 15(0.4%) болж бараг 2 дахин өссөн байна.

Хүснэгт 4. Гэмт хэргийн тоо, гэмт хэргийн төрлөөр\*

| Он   | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|--|------|------|------|------|
| Хүний амьд явах эрхийн эсрэг   | 953  | 970  | 103  | 68   |
| Хүнийг алах  | 20   | 32   | 30   | 17   |
| Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг                              | 69   | 34   | 981  | 1049 |
| Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах                   |      |      | 16   | 19   |
| Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах                      |      |      | 897  | 981  |
| Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх  |      |      | 26   | 19   |
| Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг                         | 40   | 60   | 79   | 63   |
| Хүчиндэх   | 33   | 41   | 69   | 58   |
| Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг                               |      | 5    | 5    | 11   |
| Эрүүл мэндийн эсрэг  |      |      |      | 2    |
| Хүүхдийн эсрэг   |      |      | 4    | 4    |
| Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг | 212  | 167  | 101  | 145  |
| Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг                                   |      | 1    | 3    | 1    |
| Эдийн засгийн  |      |      | 23   | 9    |
| Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг                       | 69   | 34   | 25   | 18   |
| Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах            | 8    | 9    | 13   | 15   |
| Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг                                | 14   | 23   | 5    | 8    |
| Авлигын  | 1    | 7    | 8    | 7    |
| Нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг                                     |      |      | 9    | 15   |

\*- Гэмт хэргийн ангилал өөрчлөгдсөн тул зарим үзүүлэлтүүд харьцуулах боломжгүй байв.


2019 онд нийт гарсан гэмт хэргийн 2060(59.4%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байсан бол 2016 онд 1304(46.4%), 2017 онд 2262(61.3%), 2018 онд 2340(63.4%) нь өмчлөх эрхийн эсрэг хэрэг байсан байна. Нийт өмчлөх эрхийн эсрэг хэргийн 2016 онд 944(72.4%) нь хулгайлах гэмт хэрэг байсан бол 2017 онд 1645(72.7%) нь, 2018 онд 1474(63.0%) нь, 2019 онд 1256(61.0%) нь байна. 2019 онд дээрэмдэх гэмт хэрэг 2016 оноос 2.2 дахин, залилах гэмт хэрэг 2.7 дахин өссөн байна.

#### Хүснэгт 5. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо

| Он        | Өмчлөх эрхийн эсрэг | Хулгайлах |                      |                                  |                 | Дээрэмдэх | Залилах |
|-----------|---------------------|-----------|----------------------|----------------------------------|-----------------|-----------|---------|
|           |                     | Хулгайлах | Хувийн өмч хулгайлах | Автотээврийн хэрэгслэл хулгайлах | Халаасны хулгай |           |         |
| 2016      | 1304                | 944       | 861                  | 23                               | 21              | 60        | 174     |
| 2017      | 2262                | 1645      | 1522                 | 29                               | 67              | 190       | 286     |
| 2018      | 2340                | 1474      | 1385                 | 31                               | 46              | 199       | 487     |
| 2019      | 2060                | 1256      | 1181                 | 31                               | 38              | 131       | 475     |
| 2019/2016 | 158.0               | 133.1     | 137.2                | 134.8                            | 181.0           | 2.2 дах   | 2.7дах  |
| 2019/2018 | 88.0                | 85.2      | 85.3                 | 100.0                            | 82.6            | 65.8      | 97.5    |

2016 онд 2320 хүн гэмт хэрэг үйлдэж байсан бол 2019 онд 1805 хүн болж 515(22.2%) - аар буурсан байна. 2016 онд 369(15.9%) эмэгтэй гэмт хэрэг үйлдсэн бол 2019 онд 240 (13.3%) болж 129(34.9%)-өөр буурсан байна. 2016 онд нийт гэмт хэрэг үйлдэгсдээс 18-35 насны залуучууд 1463(63.1%) байсан бол 2019 онд 1061(58.8%) болж 402(27.5%)-оор буурсан байна.

#### Дүрслэл 1. Гэмт хэрэг үйлдсэн залуучуудын эзлэх хувь, насны бүлгээр



#### Хүснэгт 6. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр

| Он                   | Бүх хүн | Эмэгтэй | насны бүлэг |       |       |       |       |       |       |       |       |       |      |
|----------------------|---------|---------|-------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|------|
|                      |         |         | 15 хүртэлх  | 16-17 | 18-24 | 25-29 | 30-34 | 35-39 | 40-44 | 45-49 | 50-54 | 55-59 | 60+  |
| 2016                 | 2320    | 369     | 21          | 70    | 534   | 505   | 424   | 275   | 208   | 140   | 86    | 34    | 23   |
| 2017                 | 1689    | 212     | 33          | 83    | 422   | 363   | 228   | 191   | 168   | 99    | 51    | 34    | 17   |
| 2018                 | 1635    | 223     | 53          | 51    | 340   | 316   | 303   | 195   | 171   | 121   | 63    | 14    | 8    |
| 2019                 | 1805    | 240     | 63          | 102   | 383   | 377   | 301   | 239   | 133   | 89    | 60    | 37    | 21   |
| <u>2019</u><br>2016% | 77.8    | 65.0    | 3 дахин     | 145.7 | 71.7  | 74.7  | 71.0  | 86.9  | 63.9  | 63.6  | 69.8  | 108.8 | 91.3 |

2016 онд гэмт хэрэг үйлдсэн иргэдийн 505(21.8%) нь 25-29 насны, 424(18.3%) нь 30-34 насны, 534(23.0%) нь 18-24 насны залуучууд байсан бол 2019 онд 383 (21.2%) нь 18-24 насны, 377(20.9%) нь 25-29 насны, 301(16.7%) нь 30-34 насны залуучууд байна.

Хүснэгт 7. Гэмт хэрэг үйлдэгсдийн нийгмийн байдал

| Он   | 2016 | 2017 | 2018 | 2019 | $\frac{2019}{2016} \%$ |
|--|------|------|------|------|------------------------|
| Төрийн албан хаагч                         | 43   | 31   | 29   | 19   | 44.2                   |
| Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч      | 179  | 123  | 88   | 121  | 67.6                   |
| Төрийн бус байгууллагын ажилтан            | 35   | 27   | 23   | 25   | 71.4                   |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч                  | 609  | 406  | 334  | 397  | 65.2                   |
| Малчин                                     | 16   | 11   | 27   | 28   | 175.0                  |
| Оюутан                                     | 63   | 33   | 27   | 42   | 66.7                   |
| Сурагч                                     | 28   | 38   | 52   | 76   | 2.7 дахин              |
| Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд | 2    | 6    | 4    | 3    | 150.0                  |
| Хоригдол                                   | 9    | 1    | 2    | 8    | 88.9                   |
| Ажилгүй                                    | 1329 | 993  | 1034 | 1075 | 80.9                   |

Гэмт хэрэг үйлдэгсдийн нийгмийн байдлыг харахад: 2019 онд гэмт хэрэг үйлдсэн төрийн албан хаагч 24(55.8%)-өөр, хувийн хэвшлийн байгууллагад ажиллагсад 58(32.4%)-аар, төрийн бус байгууллагын ажилтан 10(28.6%)-аар, хувиараа хөдөлмөр эрхлэгч 212(34.8%)-оор, оюутан 21(33.3%)-ээр, ажилгүй иргэн 254(19.1%)-өөр буурсан бол малчин 12(75.0%)-оор, сурагч 48(271.4%)-аар, сургууль завсардсан болон тэнэмэл хүүхэд 1(150.0%)-ээр тус тус өссөн байна. Гэмт хэрэг үйлдсэн сурагчдын тоо 2016 оноос 2019 оны хооронд тогтмол өссөн бол гэмт хэрэг үйлдсэн төрийн албан хаагчийн тоо тогтмол буурсан байна.


Хүснэгт 8. Гэмт хэрэг үйлдэгсдийн тоо, боловсролын түвшингээр

| Он                     | Боловсролгүй | Бага | Суурь | Бүрэн дунд | Техник мэргэжилийн болон тусгай мэргэжлийн дунд | Дээд |
|------------------------|--------------|------|-------|------------|---|------|
| 2016                   | 102          | 145  | 505   | 1149       | 86  | 333  |
| 2017                   | 58           | 141  | 355   | 866        | 63  | 206  |
| 2018                   | 39           | 124  | 318   | 902        | 67  | 185  |
| 2019                   | 40           | 141  | 455   | 928        | 69  | 172  |
| $\frac{2019}{2016} \%$ | 39.2         | 97.2 | 90.1  | 80.8       | 80.2  | 51.7 |

2019 онд гэмт хэрэг үйлдэгсдийн 40 (2.2%) нь боловсролгүй, 141(7.8%) бага, 455(25.2%) нь суурь, 928(51.4%) нь бүрэн дунд, 69(3.8%) техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 172(9.5%) нь дээд боловсролтой байна. 2016 онд гэмт хэрэг үйлдэгсдийн 102 (4.4%) нь боловсролгүй, 145(6.3%) бага, 505(21.8%) нь суурь, 1149(49.5%) нь бүрэн дунд, 86(3.7%)

техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 333(14.4%) нь дээд боловсролтой байна. 2016 оноос 2019 оны хооронд дээд боловсролтой хэрэг үйлдсэн хүний тоо тогтмол буурсан байна. Хэрэг үйлдсэн боловсролгүй хүний тоо 2016 онд 102 байсан бол 2017 онд 58 болж 44(43.1%) -өөр буурсан байна.

Дүрслэл 2. Бүрэн дунд болон суурь боловсролтой гэмт хэрэг үйлдэгсдийн эзлэх хувь



Хүснэгт 9. Гэмт хэргийн тоо, гарагаар

| Он                                 | Даваа | Мягмар | Лхагва | Пүрэв | Баасан | Бямба | Ням   |
|------------------------------------|-------|--------|--------|-------|--------|-------|-------|
| 2016                               | 473   | 453    | 458    | 438   | 387    | 310   | 292   |
| 2017                               | 596   | 535    | 548    | 560   | 565    | 430   | 457   |
| 2018                               | 612   | 554    | 541    | 592   | 490    | 425   | 478   |
| 2019                               | 525   | 546    | 513    | 520   | 516    | 433   | 417   |
| 2019/2016                          | 111.0 | 120.5  | 112.0  | 118.7 | 133.3  | 139.7 | 142.8 |
| 2019/2018                          | 85.8  | 98.6   | 94.8   | 87.8  | 105.3  | 101.9 | 87.2  |
| Гэмт хэргийн тоо, хувиар, гарагаар |       |        |        |       |        |       |       |
| 2016                               | 16.8  | 16.1   | 16.3   | 15.6  | 13.8   | 11.0  | 10.4  |
| 2017                               | 16.1  | 14.5   | 14.8   | 15.2  | 15.3   | 11.6  | 12.4  |
| 2018                               | 16.6  | 15.0   | 14.7   | 16.0  | 13.3   | 11.5  | 12.9  |
| 2019                               | 15.1  | 15.7   | 14.8   | 15.0  | 14.9   | 12.5  | 12.0  |

2016 онд гарсан нийт хэргийн 16.8 хувь нь даваа гарагт, 16.1 хувь нь мягмар гарагт, 16.3 хувь нь лхагва гарагт, 15.6 хувь нь пүрэв гарагт, 13.8 хувь нь баасан гарагт, 11.0 хувь нь бямба гарагт, 10.4 хувь нь ням гарагт тус тус гарч байсан байна. 2019 онд нийт хэргийн 15.1 хувь нь даваа гарагт, 15.7 хувь нь мягмар гарагт, 14.8 хувь нь лхагва гарагт, 15.0 хувь нь пүрэв гарагт, 14.9 хувь нь баасан гарагт, 12.5 хувь нь бямба гарагт, 12.0 хувь нь ням гарагт тус тус гарсан байна.

Гэмт хэргийн гаралтыг харахад даваа гарагт 2019 онд 525(6.3%) хэрэг гарсан нь 2016 оны даваа гарагаас 52(6.3%)-оор нэмэгдсэн байна. Ерөнхийдөө ажлын өдрийн гэмт хэргийн гаралт ойролцоо бөгөөд амралтын өдрүүдэд буурах хандлагатай байдаг байна. Амралтын өдөр буюу ням гарагт 2016 онд 292 (10.4%) хэрэг гарсан бол 2019 онд 417(12.0%) болж 125(42.8%)-аар өссөн байна. Бямба гарагт 2016 онд 310(11.0%) хэрэг гарч байсан бол 2019 онд 433(12.5%) хэрэг гарч 123(39.7%) хэргээр өссөн байна.

Хүснэгт 10. Гэмт хэргийн тоо, хэрэг гарсан цагаар

| Он                               | Цаг   |       |       |       |
|----------------------------------|-------|-------|-------|-------|
|                                  | 06-14 | 14-19 | 19-22 | 22-06 |
| 2016                             | 603   | 828   | 434   | 946   |
| 2017                             | 964   | 1069  | 566   | 1092  |
| 2018                             | 964   | 1032  | 615   | 1081  |
| 2019                             | 926   | 1028  | 597   | 919   |
| 2019/2016                        | 153.6 | 124.2 | 137.6 | 97.1  |
| 2019/2018                        | 96.1  | 99.6  | 97.1  | 85.0  |
| Гэмт хэргийн тоо, хувиар, цагаар |       |       |       |       |
| 2016                             | 21.5  | 29.5  | 15.4  | 33.7  |
| 2017                             | 26.1  | 29.0  | 15.3  | 29.6  |
| 2018                             | 26.1  | 28.0  | 16.7  | 29.3  |
| 2019                             | 26.7  | 29.6  | 17.2  | 26.5  |

2016 онд нийт гарсан гэмт хэргийн 21.5 хувь нь 06-14 цагт, 29.5 хувь нь 14-19 цагт, 15.4 хувь нь 19-22 цагт, 33.7 хувь нь 22-06 цагт тус тус гарсан байна. 2019 онд гарсан гэмт хэргийн 26.7 хувь нь 06-14 цагт, 29.6 хувь нь 14-19 цагт, 17.2 хувь нь 19-22 цагт, 26.5 хувь нь 22-06 цагт гарсан байна.

Хүснэгт 11. Гэмт хэргийн тоо, хэрэг үйлдэгдсэн газраар

| Он                   | Гэр, орон сууц | Олон нийтийн газар | Гудамж, талбай | Нийтийн тээвэр | Төрийн байгууллага | Төрийн бус байгууллага |
|----------------------|----------------|--------------------|----------------|----------------|--------------------|------------------------|
| 2016                 | 1138           | 297                | 633            | 47             | 11                 | 19                     |
| 2017                 | 1796           | 352                | 772            | 61             | 26                 | 17                     |
| 2018                 | 1703           | 358                | 810            | 37             | 32                 | 25                     |
| 2019                 | 1491           | 355                | 710            | 36             | 27                 | 16                     |
| <u>2019</u><br>2016% | 131.0          | 119.5              | 112.2          | 76.6           | 245.5              | 84.2                   |
| <u>2019</u><br>2018% | 87.6           | 99.2               | 87.7           | 97.3           | 84.4               | 64.0                   |

2016 онд нийт гарсан хэргийн 1138(40.5%) гэр орон сууцанд, 297(10.6%) нь олон нийтийн газарт, 633(22.5%) нь гудамж, талбайд, 47(1.7%) нь нийтийн тээвэрт, 11(0.4%) нь төрийн байгууллагад, 19(0.7%) нь төрийн бус байгууллагад гарсан бол 2019 онд гарсан хэргийн 1491(42.9%) гэр орон сууцанд, 355(10.2%) нь олон нийтийн газарт, 710(20.5%) нь гудамж, талбайд, 36(1.0%) нь нийтийн тээвэрт, 27(0.8%) нь төрийн байгууллагад, 16(0.5%) нь төрийн бус байгууллагад тус тус гарсан байна. 2019 онд гэр орон сууцанд гарсан хэрэг 353 (31.0%), хэргээр, олон нийтийн газарт гарсан хэрэг 58(19.5%) хэргээр, гудамж талбайд гарсан хэрэг 77(12.2%) хэргээр, төрийн байгууллагад гарсан хэрэг 2.4 дахин 2016 оноос нэмэгдсэн байна.

## Хүснэгт 12. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо, насны бүлгээр

| Он                    | Нийт хохирсон иргэн | эмэгтэй | 13 хүртэл настай | 14-17 | 18-24 | 25-29 | 30-34 | 35-39 | 40-44 | 45-49 | 50-54 | 55-59 | 60+   |
|-----------------------|---------------------|---------|------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| 2016                  | 2870                | 1249    | 58               | 66    | 352   | 556   | 507   | 413   | 304   | 227   | 144   | 113   | 130   |
| 2017                  | 3706                | 1672    | 86               | 125   | 422   | 658   | 626   | 501   | 397   | 312   | 241   | 172   | 130   |
| 2018                  | 3617                | 1647    | 71               | 97    | 377   | 609   | 637   | 475   | 410   | 333   | 236   | 195   | 177   |
| 2019                  | 3466                | 1609    | 84               | 106   | 391   | 550   | 584   | 484   | 410   | 283   | 215   | 199   | 160   |
| $\frac{2019}{2016}\%$ | 120.8               | 128.8   | 144.8            | 160.6 | 111.1 | 98.9  | 115.2 | 117.2 | 134.9 | 124.7 | 149.3 | 176.1 | 123.1 |
| $\frac{2019}{2018}\%$ | 95.8                | 97.7    | 118.3            | 109.3 | 103.7 | 90.3  | 91.7  | 101.9 | 100.0 | 85.0  | 91.1  | 102.1 | 90.4  |


2016 онд гэмт хэргийн улмаас нийт 2870 иргэн хохирсоноос 1249(43.5%) эмэгтэй, 58(2.0%) нь 13 хүртэлх насны хүүхэд 130(4.5%) 60 ба түүнээс дээш насны ахмадууд байсан байна. 2019 онд гэмт хэргийн улмаас 3466 хүн хохирсоны 1609(46.4%) нь эмэгтэйчүүд, 84(2.4%) нь 13 хүртэлх насны хүүхэд 160(4.6%) 60-аас дээш насны өндөр настан байна. 2019 онд 3466 хүн гэмт хэргийн хохирогч болсон нь 2016 оноос 596 (20.8%)-аар нэмэгдсэн байна.

## Хүснэгт 13. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая төгрөгөөр

| Он                    | нийт   | Гэмт хэргийн төрөл |        |
|-----------------------|--------|--------------------|--------|
|                       |        | хөнгөн             | хүнд   |
| 2016                  | 5544.8 | 1469.1             | 328.1  |
| 2017                  | 7848.9 | 3525.1             | 2249.7 |
| 2018                  | 7506.8 | 5257.6             | 2249.2 |
| 2019                  | 9033.5 | 6718.9             | 2314.6 |
| $\frac{2019}{2016}\%$ | 162.9  | 4.6 дах            | 7 дах  |
| $\frac{2019}{2018}\%$ | 120.3  | 127.8              | 102.9  |

2016 онд гэмт хэргийн улмаас 5544,8 сая төгрөгийн хохирол учирсан бол 2017 онд 7848,9 сая төгрөгийн, 2018 онд 7506,8 сая төгрөгийн, 2019 онд 9033,5 сая төгрөгийн хохирол учирсан байна. 2019 онд гарсан гэмт хэргийн учруулсан хохирол нь 2016 оноос 3488.7 (62.9%) сая төгрөгөөр илүү байна.

## Дүрслэл 3. Нийт зөрчлийн тоо



2016 онд нийт 38214 зөрчил гарсан бол 2017 онд 27018 зөрчил, 2018 онд 12447 зөрчил, 2019 онд 16368 зөрчил тус тус гарсан байна. 2019 онд гарсан зөрчлийн тоо 2016 оноос 12554 (57.2%) -өөр буурсан байна.